

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Баасан гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-5

- 
1. *“1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашуунсухайт-Ганицмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 3-4
  2. *“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/* 4-5

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
07 дугаар сарын 07-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл, С.Чинзориг, Т.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Ундрам.

**Нэг. “1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамьянхүү, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Серикжан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

“1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “06 дугаар” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 07 минут үргэлжилж, 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 12 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 05 минут.

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Гишүүд Баттөмөрийн Энхбаяр гишүүн гадаад томилолттой, бусад гишүүд хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрэлдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгт, Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашиунсухайт-Ганц мод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын 2023 оны 7 сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, нэн яаралтай.

Хоёр.Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар эцсийн хэлэлцүүлэг гэсэн 2 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд, өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

*Хэлэлцэх асуудал нэг, Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашиунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.*

*Ажлын гишүүн хэсгийг оруулна уу. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.*

*Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг уншиж танилцуулъя.*

*Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,*

*Монгол Улсын Засгийн газрын газраас 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашиунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.*

*Байнгын хороо чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг тогтоолын төсөлд нэг бүрчлэн тусгаж, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийлээ.*

*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг нэмж тусгасан эцсийн хувилбарын төслийг та бүхэндээ хүргүүлсэн.*

Байнгын хорооны эрхэм гишүүд  
ээ,

Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашиунсухайт-Ганицмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Эцсийн хэлэлцүүлгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.

Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон “Гашиунсухайт-Ганицмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг дууслаа. Дараагийн асуудалд оръё.

10.09 цаг

**Хэлэлцэх асуудал хоёр. “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг уншиж танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд  
ээ,

Улсын Их Хурлын 2022 оны хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай танилцах, санал, дүгнэлт, төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 162 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн танилцуулгыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар сонссон.

Тус ажлын хэсгийн танилцуулгыг сонссонтой холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хангуулах чиглэлээр “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж, Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн төслийн эцсийн хувилбарын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд  
ээ,

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

*Эцсийн хэлэлцүүлгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.*

*Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.*

*Тогтоолын төслийн талаар ажлын хэсгийн зүгээс дахин санал хураалгахаар бэлтгэсэн 1 саналаар санал хураалт явуулъя.*

*Энэ санал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос дээш хувийн санал авч дэмжигдэнэ. Саналыг уншиж танилцуулъя.*

*“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.*

*1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “06 дугаар” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг.*

*Санал хураалт явуулъя. Санал хураалт.*

*Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.*

*Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.*

*“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.*

*Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.*

*Хуралдаанд идэвхтэй оролцсон та бүхэн, гишүүддээ маш их баярлалаа.*

*10.12 цаг*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*